

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Төрийн захиргааны байгууллагын удирдах -1, гүйцэтгэх 5 албан тушаалын тусгай шалгалтын захиалгыг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 3/2426 тоот албан бичгээр Монгол Улсын Төрийн албаны зөвлөлд хүргүүлж 12 дугаар сарын 08-ны өдөр csc.gov.mn сайтад байршуулж олон нийтэд зарлуулж, 12 дугаар сарын 11-ны өдрийн 09:00 цагаас 17:00 цагийн хооронд шалгалтад орох хүсэлтэй иргэдийн материалыг khuvs gul.tu@csc.gov.mn хаягаар хүлээн авч, 12 дугаар сарын 13-ны өдөр шалгалтын комисс хуралдаж, 12 дугаар сарын 14-ны өдрийн 10 цагт тусгай шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтад бүртгүүлэхээр 8 иргэн материалаа ирүүлж тусгай болон ерөнхий шаардлагыг хангасан 6 иргэн ажлын байранд тусгай шалгалтад орж тэнцэв.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд :

Хянал шалгалт, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1. Конавируст халдварын үед эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдалд хийгдсэн хяналт шалгалт: МХЕГазрын даргын 2021 оны 01-р сарын 04-ны өдрийн 01/01 “Эмнэлэгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд” хийсэн хяналт шалгалтын талаар: Хяналт шалгалтыг ЭБХУБайцаагч Д.Амараа, ЭАХХХУБайцаагч Н.Дамбадаржаа, Л.Нямгэрэл нар 2021 оны 01-р сарын 08-ны өдрөөс эхлэн хийж байна. Хяналт шалгалтын явцын талаар аймгийн нэгдсэн эмнэлэг, 5 өрхийн эмнэлэгт хяналт шалгалтыг хийж 12 зөрчлийг илрүүлсэн, Аймгийн хэмжээнд байрлах COVID-19 шинжилгээ авах 11 түр цэгт хяналт шалгалтыг хийхэд 6 нийтлэг зөрчил илэрсэн. Хяналт шалгалтууд үргэлжилж байна.

2. МХЕГазрын даргын баталсан 2021 оны 01 дүгээр сарын 04-ны 01/02 дугаартай удирдамжийн дагуу “Тусгаарлах байрны бэлэн байдалд” төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг аймгийн нэгдсэн эмнэлгийн тусгаарлах өрөө, Их-Уул, Рашаант, Жаргалант, Цэцэрлэг сумдын тусгаарлан ажиглах байранд эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийн байдалд ЭАХХХ-ын ахлах байцаагч А.Үүрийнцолмон, ЭАХХХУБ Л.Нямгэрэл, ХАБХУБ Б.Батбилгүүн, МЭХУБ Б.Батдорж, ЭБХУБ Д.Амараа нар хяналт, шалгалт хийж ажиллаа.

3. Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтэд, ковид-19-ийн шинжилгээ авах цэгт хяналт тавих: Аймгийн хэмжээнд 535 иргэн, ААНБ-д нийт 58293м2 талбайд мэргэжлийн байгууллагаар урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийлгэсэн тухай бүр хяналт тавьсан байна. Мөн Аймгийн Засаг даргын 2021 оны 01 сарын 07-ны өдрийн А/10 дугаар захирамжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнс болон барааны зах, худалдаа үйлчилгээ төвүүд, банк санхүү, эрүүл мэндийн байгууллагуудад урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг давтан хийсэн Үүнд: 17 байгууллагын 21000 м2 талбайд халдваргүйжүүлэлтийг хийсэн. Их-Уул, Тариалан, Бүрэнтогтох, Рашаант, Жаргалант, Түнэл, Алаг-Эрдэнэ, Хатгал, Тосонцэнгэл, Арбулаг, Баянзүрх, Эрдэнэбулган, Мөрөн сумдаас түүврийн аргаар 320 сорьц авч ХӨСҮТ-д PCR шинжилгээ хийлгэсэн, Мөн аймгийн хэмжээнд 2020 оны 11-р сарын

11-ны өдрөөс хойш 13 000 түргэвчилсэн оношлуураар 11000 мянган иргэнд шинжилгээг хийсэн байна.

Газар хөдлөлтийн улмаас үүссэн нөхцөл байдлын хяналт шалгалт

Хөвсгөл аймгийн Ханх суманд 2021.01.12-ны өдөр 6.5 магнитудын хүчтэй газар хөдлөлт болсонтой холбоотой Мөрөн суманд ашиглагдаж байгаа нийтийн орон сууц, олон нийтийн барилгуудад Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 2021.01.12-ны өдрийн 23/02 дугаартай удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус шалгалтыг 2021.01.12, 14-ний өдрүүдэд гүйцэтгэж байна. Тус газар хөдлөлт нь аймгийн төвөөс баруун хойд зүгт 200 километрт Ханх сумаас баруун урд зүгт 28 километрийн зайд 01 дүгээр сарын 12-нд нийт зургаан удаагийн газар хөдлөлт болж, иргэдэд хүчтэй мэдрэгдсэн. Улаанбаатарын цагаар 05:32 цагт 6,5 магнитуд, 05:41 цагт 5,1 магнитуд, 05:47 цагт 4,6 магнитуд, 06:02 цагт 5,3 магнитуд, 06:10 цагт 5 магнитуд, 07:02 цагт 5,6 магнитудтай газар хөдлөлт болсон байна.

Мөрөн сумын 40 орон сууцны барилга, төрийн өмчийн Дэлгэр Мөрөн цогцолбор сургуулийн хичээлийн төв байр, Ахмадын асрамж үйлчилгээний барилга зэрэг объектуудын ашиглалт, чанар байдал, барилгын даацын үндсэн бүтэц хийцэд газар хөдлөлтийн улмаас эвдрэл гэмтэл үүссэн эсэхэд хяналт шалгалт хийж, оршин суугчдаас асуумж судалгаа авч ажиллаж байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.

2021.01.13-16-ний өдрүүдэд Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн ажлын баг Ханх суманд буюу газар хөдлөлтийн голомтот бүсэд ажилласан Багийн бүрэлдэхүүнд мэргэжлийн хяналтын байгууллагын 4 улсын байцаагч ажиллаж барилга байгууламжийн эвдрэл гэмтлийн байдалд үзлэг шалгалтыг гүйцэтгэж байна. Ханх сум нь олон жилийн цэвдэг үргэлжлэн тархсан бүс нутаг бөгөөд газар хөдлөлтийн 9 баллын идэвхтэй бүсэд хамаарна. Ханх сумын төрийн өмчийн нийт 8 барилга байгууламжид эвдрэл гэмтэл үүссэн байна.

Цагаан-Үүр сумын 100 ортой дотуур байрын барилгын каркасын дүүргэгч ханын багана дам нуруутай уулзах хэсэгт ан цав гарсан, фасадны өнгөлгөөнд цууралт гарсан талаар мэдээллийг Цагаан-Үүр сумын ЗДТГазраас ирүүлсэн. Тус барилга нь 2020 оны 12-р сард ашиглалтад орсон 2 давхар барилга.

Рэнчинлхүмбэ сумын хэмжээнд өглөө үүрээр 5 цаг 33 минутад газар хөдлөлтийн эхний үзэгдэл маш хүчтэй чичирхийлж ойролцоогоор 1 минут орчим үргэлжилсэн. Газар хөдлөлтийн улмаас ЕБС-ийн сургуулийн дотуур байрын барилгын хананд босоо, ташуу чиглэлийн ан цав, цууралт гарсан, бусад байгууллагуудын барилга байгууламжууд хэвийн байгаа талаар мэдээлэл ирүүлээ. 100 ортой дотуур байрын барилга нь 2016 онд ашиглалтад орсон 2 давхар каркасан барилга.

Гэмт хэрэг зөрчлийн чиглэлээр.

2020 онд нийт 2266 зөрчлийн гомдол бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн шинжтэй 192 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс 149 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг үүсгэж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 134 иргэнийг шүүхээр 7-30 хоног баривчлуулж, 15 иргэнд торгуулийн арга хэмжээнд оногдуулсан. Өмнөх онтой харьцуулбал зөрчлийн хэрэг нь 22, шүүхээр шийдвэрлэсэн

нь 15, торгуулийн арга хэмжээ оногдуулсан нь 7 тохиолдлоор тус тус өссөн үзүүлэлттэй байна. Өссөн үзүүлэлт нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон илрүүлэлт сайн байна гэж дүгнэж болно. Гэр бүл, хүүхдийн тусламжийн 70382121 утсыг 24 цагаар ажиллуулж, нийт 13 дуудлага ирснийг 100% шийдвэрлэн ажилласан байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Боловсролын чиглэлээр:

“Хүнсний тусламж үзүүлэх тухай” БШУ-ны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/162 тоот тушаалын дагуу цэцэрлэг, дотуур байрын хүүхдийн хоол, хүнс болон үдийн цайнд зарцуулахаар нөөцөлсөн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүнс тэжээлийн дутагдалд орох эрсдэлтэй зорилтот бүлгийн өрхөд хүргэх арга хэмжээг 12 сарын 01-04-ны өдрүүдэд зохион байгууллаа. Нийт 23 сум, 1 тосгоны ЕБС-26, СӨБ-40 байгууллагаас зорилтот бүлгийн **2602** хүүхдэд, **130,979,472** төгрөгийн өртөг бүхий хүнсний дэмжлэг тусламжийг хүргэлээ.

Тогтвортой хөгжлийн боловсрол эрдэм шинжилгээний хурал онлайнаар зохион байгуулагдлаа.

12 сарын 01-ны өдөр Хөвсгөл аймгийн ЕБС, СӨБ-ийн удирдлагуудтай цахим хурал зохион байгуулав.Хэлэлцсэн гол асуудал хүнсний тусламж үзүүлэх чиглэлээр анхаарах асуудал, зөвлөмж, төсөв хөрөнгө оруулалттай холбоотой мэдээлэл, цаг үеийн ажлуудыг зөвлөлдөж жилийн ажлын тайлан мэдээ ирүүлэх хугацааг тогтов. 30 сургууль, 40 цэцэрлэг оролцов.

12 сарын 02-ны өдөр Мөрөн сумын ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудтай уулзаж хүүхэд хамгааллын чиглэлээр хийгдэж буй ажил үйлчилгээний талаар мэдээлэл солилцов.

12 сарын 08 ны өдөр БСУГ-т Хууль зүйн хүрээлэн, АЗДТГ Хууль зүйн хэлтсээс хамтарсан сургалт цахимаар зохион байгуулагдсан. Тус сургалтад Мөрөн сумын сургуулийн нийгмийн ажилтнууд танхимаар, сумын нийгмийн ажилтнууд цахимаар оролцлоо.

12 сарын 09-11 ны өдрүүдэд ЕБС, СӨБ-үүдээс теле хичээлийн хэрэгжилт, боловсролын салбар дахь хөрөнгө оруулал, багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр хийгдэх ажлуудын саналыг нэгтгэн авлаа.

12 сарын 11-ны 16.00 цагаас УИХ-ын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан, БШУ-ны сайд Л.Цэдэвсүрэн, яамны газрын дарга нар, Хөвсгөл аймгийн ЕБС, СӨБ-төлөөлөл оролцсон цахим хурлыг зохион байгууллаа. Энэ цаг хугацаанд хийж хэрэгжүүлж буй ажлуудын товч мэдээлэл, хөрөнгө оруулалттай холбоотой саналаа хүргүүлэв.

12 сарын 11-ны 17.30-д БШУЯ-наас Боловсролын газрын дарга нартай Цаг үеийн асуудлаар /Боловсролын тухай ерөнхий хууль, СӨБ, бага, дунд боловсролын

тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцэх/ шуурхай цахим хурлыг зохион байгуулсан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 12 сарын 11-ны өдрийн А/180 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад 2020-2021 оны хичээлийн жилийн нэгдүгээр улирлын теле, цахим хичээлийг бататгах, суралцагчдын сурах үйлийг дэмжих зорилготой давтлагыг сургуулийн орчинд 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн зохион байгуулахыг зөвшөөрлөө. Давтлага зохион байгуулахад мөрдөх зааврыг баталсан. Энэ шийдвэр гарсны дагуу ЕБС захирал, сургалтын менежер, эмч, нийгмийн ажилтнуудтай цахим хурлыг 12 сарын 12-ны өдөр зохион байгуулсан.

2020 он 12 сарын 14-ны өдөр БШУ-ны яамнаас “Боловсролын ерөнхий хууль”-ийн хэлэлцүүлгийг онлайнаар зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт 35 сургууль, 42 цэцэрлэг, 25 цэгт холбогдож, 35 захирал, 42 эрхлэгч, 78 сургалтын менежер, арга зүйч, 110 багш ажилтан 89 санал хүсэлтийг хэлэлцлээ. ЕБС, СӨБ-үүдээс тус хуультай холбоотой саналыг нэгтгэж БШУЯ-нд хүргэх ажлыг зохион байгуулав.

Сургуулийн захирал-35, цэцэрлэгийн эрхлэгч-42 нарын жилийн ажлын тайланг дүгнэх ажлыг 12 сарын 15-18 ны өдрүүдэд зохион байгууллаа.

Боловсролын үнэлгээний төвөөс сургуулийн захирал, сургалтын менежер нарт зориулсан “Үр дүнд суурилсан үнэлгээний шинэчлэл” сэдэвт цахим сургалтыг 2020 оны 12 сарын 23-24 өдөр зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:

“Нэг цэгийн үйлчилгээний төв”-д 21 хүн үйлчлүүлсэн байна. Үүнээс нийт хүүхэд 7 /эмэгтэй-3, эрэгтэй-4/ насанд хүрэгч 14 /эрэгтэй-4, эмэгтэй-10/ үйлчлүүлсэн байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд д 11 дүгээр сарын 20-оос 12 дугаар сарын 20-ны байдлаар нийт 12 дуудлага бүртгэгдсэн байна. Шийдвэрлэлт: 2 өрхөд холбогдох үнэлгээг хийж, хүнсний дэмжлэг, 2 дуудлагын асуудал хяналтад, 8 дуудлагыг харьяа хамтарсан багт шилжүүлсэн байна.

“Яг одоо” арга хэмжээний хүрээнд “Гэр бүлийн боловсрол олгох” лайв хийж 4260 хүнд хүрсэн байна. Залуу гэр бүлд зориулсан “Гэр бүлийн сэтгэл зүйн боловсрол” олгох лайв хийж 4260 хүний хандалт авсан байна.

Монгол залуу хүний эрмэлзэх 9 зүйл TV шторк, Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаа болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар нэвтрүүлэг бэлтгэн телевизээр дамжуулан олон нийтэд хүргэв.

2020 оны 12 дугаар сард Хөвсгөл аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс 4123, 5323, 4586 дугаартай 3 захирамж ирсэн. Энэхүү захирамжийн хүрээнд газрын даргын тушаалаар 3 шинжээчийн баг томилогдон ажиллаж 15 настай /эм/, 14 настай /эр/, 3 настай /эр/, 1 ой 10 сартай /эм/, 13 настай /эр/ 8 настай /эр/ нийт

6 хүүхдийн асран хамгаалагч өөрчлүүлэн тогтоох захирамжийн дагуу гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ /5/, хүүхдийн эрсдэлийн үнэлгээ /6/-г хийж ажилласан байна.

Азийн хөгжлийн банк Японы ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй 9198-МОН төсөл хэрэгжиж эхэлсэн байна.

Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн 2020 оны 11 дүгээр сарын 22-оос 12 дугаар сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 13 төрлийн ажил, үйлчилгээнд 9 гэр бүл, 34 хүүхдэд үйлчилгээ, 12 өрхөд хүнсний дэмжлэг үзүүлэн ажилласан байна. 3 төрлийн зөвлөмжийг цахимаар хүргэн ажиллаж, 7174 хандалт авсан байна.

“Гэр бүлийг дэмжих хөтөлбөр”-т хамрагддаг хөдөөгийн 23 сумын 300 өрхөд 30000 төгрөгний хүнсний дэмжлэг үзүүлэх 9.000.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэв. Тус хөтөлбөрт хамрагддаг Мөрөн сумын 60 өрхөд сайн дураараа нэгдсэн 3 сайн дурын нэгдэлтэй хамтран хүнс, эрүүл ахуйн багц олгох ажлыг зохион байгуулсан. Энэхүү ажилд олон хүүхэдтэй 0-18 насны хүүхэдтэй 30 гэр бүл, ам бүл олонтой 15 гэр бүл, 1-3 хүүхэдтэй 15 гэр бүл хамрагдсан. -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн А/213, А/216 дугаар тушаалаар газрын дэргэдэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”, “Залуучуудын хөгжлийн төв”-д хяналт шинжилгээ үнэлгээ хийв. Үнэлгээг агентлагт хүргүүлэн ажиллалаа.

Байгууллагын дэргэдэх “Шилдэг эцэг эхийн зөвлөл” шалгаруулах болзолт уралдааныг зохион байгуулж, 8 байгууллагыг шалгаруулав.

Аймгийн БСУГ, Монгол цэргийн холбооны Хөвсгөл аймаг дахь салбартай хамтран “Эх оронч үзэл-Бидний оролцоо” сэдэвт илтгэлийн уралдааныг зохион байгуулж, 3 илтгэлийг шалгаруулав.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн 12 сарын олголт

№		Хүний тоо	Мөнгөн дүн
1	Тэтгэвэр	3077	8,394,092,120
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	3741	3,426,844,630
3	АДНМТэтгэмж	2200	1,692,159,390
4	Цаатны тэтгэмж	397	745,825,250
5	Хүнс тэжээл	14726	3,367,984,000
6	ОНОТХҮ	613	25,914,200
7	Ахмад настны хөнгөлөлт	17509	1,211,949,780
8	ХБИ-ний хөнгөлөлт	1866	339,525,055
9	Одонгийн тэтгэмж	11018	1,455,200,000
10	Насны хишиг	5798	933,420,000
11	Өрх толгойлсон эхийн тэтгэмж	509	435,058,760

12	Цалинтай эхийн тэтгэмж	8257	1,633,053,231
13	Алдар цолтон ахмад настан	78	73,199,070
14	ОТАДНМТ	99	118,458,000
15	Ихэр хүүхэд	22	51,000,000
16	Жирэмсэн нярай	3065	235,356,549
	Нийт	72.975	24,139,040,035

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, холбогдох бусад тайлан гарган хүргүүлсэн.

Мөн төрийн захиргааны албан хаагчдын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэн үнэлгээ хийсэн.

Цагаан-Үүр сумын мэргэжилтэн Д.Ариунаа нь өндөр настны тэтгэвэрт гарсан тул 23.3 сая төгрөгийн нэг удаагийн тусламжийг олгож сул ажлын байрны захиалгыг аймгийн ТАСЗ-д хүргүүлсэн.

Тус байгууллагад тогтвортой ажиллаж байгаа ердийн галлагаатай гэр байшинд амьдардаг 10 албан хаагчид тус бүр 114000 төгрөгийн дэмжлэг олгосон.

Мөрөн суман дахь ахмадын амралтын газрын байранд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар засвар үйлчилгээг хийж дуусгасан. Мөн аймгийн мэргэжилийн хяналтын газарт үйл ажиллагаа эхлүүлэх хүсэлт хүргүүлсэн

Эрүүл мэндийн чиглэлээр:

Эрүүл мэндийн газрын дарга М.Үүрийнбаяр аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа хувийн хэвшлийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудтай уулзлаа. Уулзалтаар 2020 онд хийж хэрэгжүүлсэн ажил, 2021 онд хийж гүйцэтгэх ажлын саналыг хэлэлцэж “Ковид-19” цар тахлын үеийн бэлэн байдал, халдвар хамгаалал болон ковидын үед хамтран ажиллах талаар ярилцлаа. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд цар тахлын үед Эрүүл мэндийн газартай хамтран ажиллахаар тохиролцлоо.

2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр “Анагаах увидас” сувилахуй, сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх төв нээлтээ хийлээ. Тус төвийг ахмад эмч Ж.Наранчулуун өөрийн хөрөнгө оруулалтаар гэр бүлийнхнийхээ хамт бүтээн байгуулж, үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрлөө авч дөрвөн хүнийг ажлын байраар ханган ажиллахаар боллоо.

ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр "КОВИД ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН СУМЫН ЭМБ-ЫН БАГИЙН ЭМЧ НАРЫГ ЧАДАВХЖУУЛАХ" төсөл амжилттай хэрэгжиж байна. Уг төслийн хүрээнд ЭМГ-ын А/99 тушаалаар ЭМГ-ын дэргэдэх сургалтын зөвлөх багийг томилж, Монголын сумын эмч нарын холбоо, ЭМХТ, АШУҮИС-тай хамтран 16 эмч,

мэргэжилтнийг үндэсний сургагч багшаар бэлтгэлээ. Бэлтгэгдсэн сургагч багш нар 4 бүсэд 114 багийн эмч, их эмч, жолооч нарыг сургалтад хамруулсан.

Аймгийн хэмжээнд гуравдагч шатлалын тусламж үйлчилгээг иргэдэд шуурхай, чанартай хүргэж, иргэндээ ээлтэй үйлчилгээг багаар хамтран үзүүлсэнд талархаж 2020 оны “Шилдэг тасаг хамт” олноор МЭС ЗАСЛЫН ТАСГИЙН ХАМТ ОЛОН, “Цахим эмнэлэг” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж шинэ, технологийг нэвтрүүлэн үр дүнтэй ажилласанд талархаж 2020 оны шилдэг “Мэдээлэл технологийн инженер”-ээр Нэгдсэн эмнэлгийн Инженер техникийн албаны дарга, сүлжээний инженер Б.Бүдрагчаа нар тус тус тодорч шагналаа гардан авлаа.

2020 онд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн ЭМБ-аас “Цээнэ” эмнэлэг үйл ажиллагаагаараа манлайлан иргэдэд үзүүлж буй тусламж үйлчилгээ, үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаа шинэ, технологээр манлайлан Шилдэг хувийн хэвшлийн ЭМБ-аар шалгарлаа.

2021 онд Сумын эрүүл мэндийн төвүүдэд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслүүдийг 15 багцаар 372 225 550 сая төгрөгний төсөвт өртөгт тооцоон Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн ажилласан. Мөн 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хурал боллоо. Тус хурлаар шинээр байгуулах 1 байгууллагын төслийг дэмжиж, 1 эмнэлэг, 2 эмийн санд тусгай зөвшөөрөл шинээр олгож, 2 эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж, 2 эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо.

Монгол Улсын засгийн газрын 89 дүгээр тогтоолд заасан цаглабарын дагуу дараах үйл ажиллагааны тайланг аймгийн Засаг даргын Тамгын газар болон Эрүүл мэндийн яаманд хүргүүлээ. Үүнд:

1. ЗГҮАХ-ын хэрэгжилтийн үнэлгээ- 89,2% өмнөх оноос 12,8% иар өссөн /76,4%/

2. Аймгийн ЭЗНХҮЧ-ийн үнэлгээ-80 % өмнөх оноос 0,5% иар буурсан /85%/

3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт-94,1% өмнөх оноос 5,4% иар өссөн / 88,7%

4. Үндэсний болон дэд хөтөлбөр, төлөвлөгөө, стратегийн хэрэгжилт-83,6% өмнөх оноос 1,97%-иар өссөн. /689 заалт/

5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт- Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол – 2 үүнээс 100%-тай 3 заалт дундаж 100, Засгийн газрын тогтоол – 16, үүнээс 100%-11, 70%- 8, 40%-4, үнэлэх боломжгүй - 2, дундаж хэрэгжилт 80%, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл –5, үүнээс 100%-3, 70%-2 дундаж хэрэгжилт-88% /23/

6. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 91,7 %тай гарсан.

7. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 89.4%-тай. Өмнөх оноос 1,3% иар өссөн үр дүнтэй байна. /84,15%/ нийт 7 нэр бүхий бодлогын баримт бичгийн 1039 заалт 349 шалгуур үзүүлэлтэд үр дүн гүйцэтгэлийн үнэлгээг батлагдсан цаглабарын дагуу хийж ажиллалаа.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Мал аж ахуйн өвөлжилт

2020-2021 он өвөл хавар 23 сум 1 тосгоны 128 багийн нутагт 9079 хот айл, 17014 малчин өрхөд 6156.3 мянган толгой мал өвөлжиж байна. Малын төрлөөр авч үзвэл тэмээ 2.5 мянган толгой, адуу 365.1 мянган толгой, үхэр 521.1 мянган толгой, хонь 2957.3 мянган толгой, ямаа 2310.2 мянган толгой буюу хонин толгойд шилжүүлснээр 10731.5 мянган толгой мал өвөлжихж байна.

Отроор: Өөрийн аймгийн сумдад: 17 суманд 241 өрхөд 760 иргэн, 105168 толгой мал,

Гадна аймгийн нутагт: Завхан аймгийн Тосонцэнгэл, Тэлмэн, Их-Уул сумдад 3 өрхийн 622 төл мал, Цэцэрлэг, Жаргалант сумаас, Архангай аймгийн 7 суманд Жаргалант сумын 20 өрхийн 7649 тол.мал, Баянхонгор Гурван булаг суманд Жаргалант сумын 1 өрхийн 450 төл мал, Хэнтий аймгийн Хэрлэн Баян улаан суманд Жаргалант сумын 1 өрхийн 360 тол.мал, Булган аймгийн Баян Агт суманд Галт сумын 1 өрхийн 440 төл, мал нийт 5 сумын 26 өрхийн 9521 толгой мал өвөлжиж байна.

Гадна аймгаас: Булган аймгийн Баян агт сумаас Их-Уул суманд 2 өрхийн 858 тол.мал, Завхан аймгийн Их-Уул сумаас Чандмань-Өндөр суманд 13 өрхийн 1201 толгой мал тус тус отроор өвөлжиж байна.

Аймгийн нөөц: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны19 дүгээр тогтоолоор аймгийн нөөцөд 800 тн өвс, 200 тн тэжээл бэлтгэх албан даалгавар өгснөөс одоогоор аймгийн нөөцөд /МХСанд/ 166,2 тн өвс, 29,8 тн тэжээлийн үлдэгдэлтэй байна. Аймгийн аюулгүй нөөц бүрдүүлэхээр 142,0 сая төгрөгөөр 3000 боодол буюу 60 тонн өвс, 8583 боодол буюу 171,6 тонн ногоон тэжээл авахаар тендер зарлаж гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулах шатандаа явагдаж байна. /Сондоргоо ХХК/

Сумын аюулгүйн нөөцөд: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны19 дүгээр тогтоолоор 4800 тн өвс бэлтгэхээс 1394 тн (29,0%) өвс, 1200 тн тэжээл бэлтгэхээс 289 (24%) тн тэжээл бэлтгэсэн.

Малчид иргэд хүчээр: 202624 тн байгалийн хадлан, 13508 тн давс, хужир шүү, 366 тн гар тэжээл бэлтгэхээс 153313 тн байгалийн хадлан, 7982 тн давс, хужир шүү, 242 тн гар тэжээл, 2631 тн ногоон тэжээл, үйлдвэрийн тэжээл 153 тн, дарш ногооны хаягдал 814.1тн бэлтгэж 76.8 хувьтай байна.

Өвөлжилтийн талаар:

Баянзүрх сумын Хайс багийн Хулгана, Хужирт, Хайсын эх, Мөрөнгийн эх Урт бүгт зэрэг нутгуудаар 15-30 см зузаан цастай, 35С-40С хүйтэн байгаа бөгөөд энэ газруудад өвөлжиж байгаа 56 өрх Дэлгэрмөрөн гол руу бод малаа оторлохоор явж байна.

Ханх сумын Тураг, Хороо, Төвийн багуудын хэмжээнд нийт 525 өрхийн 54000 толгой мал өвөлжиж байна. Сумын удирдлагууд болон холбогдох мэргэжилтнүүд багуудаар явж өвөлжилтийн байдалтай танилцсан. Өвөлжилтийн хувьд тус суманд олон жилийн дунджаас их цас орж эрс хүйтэрч шуурснаас цас хатуурч мал бэлчээрлэхэд хүндрэлтэй байгаа. Хороо багийн Хороо голын баруун тал Бөөрө, Буянт орчимд 10-15 см зузаан, Улаан мод, Тохмог, Мунгараг орчимд 15-20 см, Ходон, Оёг орчимд 20-25 см хэмжээтэй ба зарим хунгарласан газраа үүнээс зузааран шуурч хатуурсан, Тураг багт нийт нутгаар 2-3 удаа цас орж цасны зузаан 10-15 см Таана, Тураг, Шугнуул, Той, Ноён гол, Сэвсүүл, Анжигас, Далбаа, Борсогт 10-25 см хатуурч хунгарласан байна. Цаашид дахин цас орвол өвөлжилт хүндрэх төлөвтэй ба малчид хадлан хангалтгүй бэлтгэснээс болон цаг агаарын онцлогоос шалтгаалж өвс тэжээлийн дутагдалд орох байдалд шилжээд байна.

Энэ жилийн хувьд өвсний гарч муу байгалийн хадлан муутайгаас хадлан бэлтгэлийн ажил өнгөрсөн жилийн 70% д хүртэл бэлдсэн. Малчид өөрсдийн хүчээр бэлтгэсэн өвс хадлангийн 40 хүртэлх хувийг хэрэглээд дуусаж байна.

Сум дотроо одоогоор 23 өрхийн 6300 толгой мал оторлож байна.

Рэнчинлхүмбэ сумын хэмжээнд 239008 толгой мал өвөлжиж, сум дотроо 28 өрхийн 5500 толгой мал отроор өвөлжиж байна. Цас 10-15 см зузаан цастай бэлчээр муу байгаагаас өвөлжилт хүндрэх төлөвтэй байна. Нэгдүгээр багийн Нуурын эх, Баян, Ивэд, хоёрдугаар багийн Битүү, гуравдугаар багийн Нарийн хороогийн бэлчир орчимд 93 өрхийн 65000 толгой мал хүндрэх төлөвтэй байна.

Аймгийн хэмжээнд тэжээлийн олдоц муу, үнэ өндөр байна. Хивэг -20000-22000 төгрөг байна. Рэнчинлхүмбэ сум, Цагаан-уул сумдад 1 уут /25кг/ 25000 төгрөг байна.

Газар тариалангийн салбар:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны чиглэлийн дагуу улаанбуудай урамшуулал олгох ажил хийгдэж байна. Урамшуулалд 31 аж ахуйн нэгжийн 10690,2 тн улаанбуудайнд урамшуулал олгохоор материалыг хүлээн аваад байна. Орон нутгийн гурилын үйлдвэр Алтан-Дуулга ХХК-д гурил үйлдвэрлэх зориулалтаар 2036,1 тонн улаанбуудай хүлээн авсан.

Өвөлжилтийн талаар:

Баянзүрх сумын Хайс багийн Хулгана, Хужирт, Хайсын эх, Мөрөнгийн эх Урт бүгт зэрэг нутгуудаар 15-30 см зузаан цастай, 35С-40С хүйтэн байгаа бөгөөд энэ газруудад өвөлжиж байгаа 56 өрх Дэлгэрмөрөн гол руу бод малаа оторлохоор явж байна.

Ханх сумын Тураг, Хороо, Төвийн багуудын хэмжээнд цасны зузаан 20-25 см, зарим газраа хунгарлаж, шуурч хатуурсан, Тураг багт нийт нутгаар 2-3 удаа цас орж цасны зузаан 10-15 см Таана, Тураг, Шугнуул, Той, Ноён гол, Сэвсүүл, Анжигас, Далбаа, Борсогт 10-25 см хатуурч хунгарласан байна. Тус суманд цас олон жилийн дунджаас их орж эрс хүйтэрч шуурснаас цас хатуурч мал бэлчээрлэхэд хүндрэлтэй болж байна. Энэ жилийн хувьд өвсний гарч муу байгалийн хадлан муутайгаас хадлан бэлтгэлийн ажил өнгөрсөн жилийн 70 хувь бэлтгэсэн ба өвс хадлангийн 40 хүртэлх хувийг хэрэгцээлээд байна.

Рэнчинлхүмбэ Цас 10-15 см зузаан цастай бэлчээр муу байгаагаас өвөлжилт хүндрэх төлөвтэй байна. Нэгдүгээр багийн Нуурын эх, Баян, Ивэд, хоёрдугаар багийн Битүү, гуравдугаар багийн Нарийн хороогийн бэлчир орчимд 93 өрхийн 65000 толгой мал хүндрэх төлөвтэй байна.

Аймгийн хэмжээнд тэжээлийн олдоц муу, үнэ өндөр байна. Хивэг -20000-22000 төгрөг байна. Рэнчинлхүмбэ сум, Цагаан-Уул сумдад 1 уут /25кг/ 25000 төгрөг байна.

“Монгол мал” болон “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, “Эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангуулан биелэлт, үр дүнг тооцон ажиллалаа. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2019 оны 06 дугаар сарын 05 ны өдрийн А/178 дугаар тушаалаар батлагдсан, “Малын эмийн үлдэгдлийн хяналт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг 2020 оны 1 дугаар улиралд багтаан аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулуулах төлөвлөгөөний дагуу, Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/203 “Дэд хөтөлбөр батлагдаж, дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хэсэг байгуулах тухай” захирамж гаргуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мал, амьтны сэг зэмийг цуглуулах, устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг орон нутагт зохион байгуулах, отор нүүдлийн болон мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд: Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 01, 02, 03-р албан даалгаврын хэрэгжилтийг хангах тухай 01/160, 02, 03, 04, 05 дугаарын ажлын нэгдсэн удирдамжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, биелэлтийг тооцон, дүн мэдээг тухай бүр МЭЕГ-т хүргүүлэн тайлагнаж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 62, 178 дугаар тогтоол, аймгийн засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/82 захирамж, байгууллагын даргын 2020.02.24-ны өдрийн А/13 тоот тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан аймгийн онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 178 дугаар тогтоолоор “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тухай”, Улсын Онцгой комиссын 34,35-р хурлын тэмдэглэл зэрэгт Онцгой байдал тогтоосонтой холбогдуулан МЭЕГ-ын даргын 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 01/1205

дугаартай “Ажил эрчимжүүлэх тухай”, “Мал махны аяны хүрээнд МЭГэрчилгээ” 11 дүгээр сарын 11-ний А/267 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/29 дугаар тушаалаар “Байгууллагын хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах” чиглэлийн дагуу 11 дүгээр сарын 11-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд ажиллагсдыг хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган ажиллаж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7 нэрийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 816,7 мянган толгой мал хамруулахаар төлөвлөснөөс дархлаажуулалтын арга хэмжээнд 810,6 мянган толгой мал хамрагдаж гүйцэтгэл 99,2 хувьтай хийгдээд байна. Бруцеллөз өвчний дархлаажуулалтад 1392,0 мянган төл мал хамрагдаж гүйцэтгэл 99,3 хувьтай хийгдэж 213,9 сая төгрөгний санхүүжилт хүссэн материалыг МЭЕГ-т хүргүүлээд байна. Иргэд, хуулийн этгээдээс санхүүжүүлэх 3 нэрийн өвчний дархлаажуулалтад 54.0 мянган толгой мал хамруулахаар төлөвлөснөөс 58,9 мянган толгой мал хамрагдаж 109 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн чиглэлээр

1. Эко сургууль хөтөлбөрт шинээр хамрагдаж байгаа 8 сургуулийн анхан шатны сургалт онлайнаар зохион байгуулагдлаа.
2. БОАЖ-ын салбарын 16 үндэсний хөтөлбөр болон аймгийн 6 дэд хөтөлбөрүүдэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, ХШҮДАХ-т хүргүүлээ
3. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулсан.
4. Аймгийн БСУГ-тай хамтран “Тогтвортой хөгжилд тулгамдаж буй асуудал, шийдэл” илтгэлийн уралдааныг зохион байгуулж, 5 илтгэл ирснээс эхний 3 байрыг шалгаруулж, урамшууллаа. 1-р байрт ЭДЦС-ийн мэдээлэл зүйн багшийн “ЭЕШ-ийн “Цахим-ЭЕШ” системээр Хөвсгөл аймгийн нийт 12-р ангийн сурагчдыг хөгжүүлэх нь” сэдэвт илтгэл, Түнэл сумын багш Г.Дашмаа “Тогтвортой хөгжлийн тухай ойлголт ухагдахуун-Тогтвортой хөгжлийн талаарх хүмүүсийн мэдлэг ойлголт”, Авьяас сургуулийн багш Батцэцэгийн “Ирээдүйгээ золиослохгүйгээр өнөөдрөөс суралцъя” илтгэлүүд шалгарлаа.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Х.ГАН-ОЧИР

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА